- 10.1.** Баталгаат хугацааны түрш болон энэхүү Баталгааны нөхцөл, болзлуудын дагуу Сэндвик нь хийц, материалын хувьд доголдолтой болох нь тогтоогдсон аливаа Сэндвиковийн Барааг энэхүү Баталгааны 7-р хэсэгт заасны дагуу (өөрийн сонголтын дагуу) засаж өгөх эсхүл төлбөрийг нөхөн олгох эсхүл сольж өгнө гэдгийг баталж байна.

11. Баталгаат хугацаа

- 11.1. Баталгаат хугацаа эхлэх.** Баталгаат хугацаа нь дор дурдсаны дагуу эхэлнэ. Үүнд:

- 11.1.1. Сэндвиковийн Тоног төхөөрөмжийн хувьд: Ашиглалтад оруулсан өдөр эсвэл Сэндвик Баталгааны бүртгэлийн маягтад гарын үсэг зурсан өдрийн аль эхэнд тохиосон өдөр нь; мөн
- 11.1.2. Сэндвиковийн Сэлбэг хэрэгсэл, Сэндвиковийн Чулуулгийн багаж хэрэгсэл, Сэндвиковийн Богино хугацаанд элдэгдэх бараа болон бутлах, шигших төхөөрөмжийн шийдлийн хувьд: Хүргэлт хийсэн өдөр эхэлнэ.

- 11.2. Баталгаат хугацаа дуусах.** Баталгаат хугацаа нь Худалдан авагчид Хүргэлт хийснээс хойш арван найман (18) сарын дараа эсвэл дор дурдсан бүтээгдэхүүний ангилал тус бүрийн баталгаат хугацааны аль эхэлж тохиосон өдөр дуусна. Үүнд:

11.3. Бутлуур, Нунтаглагч, Шигшүүр болон Тэжээгч

- 11.3.1. Бутлуур: арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) тээвэрлэлтийн цаг;
- 11.3.2. Зөөврийн нунтаглагч: арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) цаг;
- 11.3.3. Зөөврийн шигшүүр болон тэжээгч: арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) цаг.

- 11.3.4. Суурин нунтаглагч: арван хоёр (12) сар;
- 11.3.5. Суурин шигшүүр болон тэжээгч: арван хоёр (12) сар.

11.4. Өрмийн машин

- 11.4.1. Гадаргуугийн өрмийн машин: арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) хөдөлгүүрийн цаг байна. Энэ нь уртасгасан баталгаатай дараах эд ангиудад хамаарахгүй: компрессорын моторын гол (Air Ends): арван хоёр (12) сар цагийн хязгааргүй; бүлүүрт шахуурга болон мотор: арван хоёр (12) сар цагийн хязгааргүй; гидравлик чулуун өрөм: арван хоёр (12) сар эсвэл нэг мянган (1000) цохилтын цаг;
- 11.4.2. Газрын гүний цохилтот өрмийн машин: арван хоёр (12) сар;
- 11.4.3. Гидравлик чулуун өрөм: арван хоёр (12) сар эсвэл нэг мянган (1000) цохилтын цаг;
- 11.4.4. Гадаргуугийн өрмийн машин: арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) хөдөлгүүрийн цаг. Энэ нь уртасгасан баталгаатай дараах эд ангиудад хамаарахгүй: компрессорын шураг: арван хоёр (12) сар цагийн хязгааргүй; бүлүүрт шахуурга болон мотор: арван хоёр (12) сар цагийн хязгааргүй; өрмийн толгой: арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) хөдөлгүүрийн цаг;
- 11.4.5. Өрөмдлөгийн алх (DTH) (шинэ өрмийн машинтай хамт худалдаж авсан тохиолдолд): хүргэлтээс хойш гурван (3) сар;
- 11.4.6. Газрын гүний өрмийн машин: арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) гидравлик хүчний блок цаг, гэхдээ бэлэн суурилүүлсан холхих хурдасгагчийн хувьд нэг мянган (1000) идэвхтэй ажиллагааны цаг;
- 11.4.7. Эргэлтэт өрмийн машин болон өндөр даралтын өрмийн машин: арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) хөдөлгүүрийн цаг байх бөгөөд энэ нь дараах уртасгасан баталгаатай эд ангиудад хамаарахгүй. Үүнд: компрессорын моторын гол (air ends): хорин дөрвөн (24) сар цагийн хязгааргүй; өрмийн толгой: арван хоёр (12) сар цагийн хязгааргүй; бүлүүрт шахуурга болон мотор: арван хоёр (12) сар цагийн хязгааргүй; тэжээгч ба хөшүүргийн цилиндр: арван хоёр (12) сар цагийн хязгааргүй;
- 11.4.8. Хайгуулын өрмийн машин: арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) хөдөлгүүрийн цаг.

11.5. Ачилт, Тээвэрлэлт

- 11.5.1. LHD буюу ачих, тээвэрлэх, буулгах ачигч машин болон ачааны машин: арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) хөдөлгүүрийн цаг (цахилгаан хэрэгслийн хувьд ажиллагааны цаг байна);
- 11.5.2. Түргэн салгах системийн төхөөрөмжүүд: зургаан (6) сар.

11.6. Механик зүсэлтийн машин

- 11.6.1. Тоног төхөөрөмж: арван хоёр (12) сар;

11.6.2. Газрын гүнд тээвэрлэлт хийх машин болон тусгай зориулалтын бага оврын ачааны машин: арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) зөөвөрлөлтийн цаг;

11.6.3. Зүсэлтийн машины дагалдах хэрэгсэл: Хүргэлтийн өдрөөс хойш зургаан (6) сар.

11.7. Газрын гүний Хурдасгагч болон Компрессор

11.7.1. Холхих хурдасгагч: арван хоёр (12) сар эсвэл нэг мянган (1000) ажиллагааны цаг;

11.7.2. Шурагт хурдасгагч болон компрессор: арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) ажиллагааны цаг.

11.8. Систем

11.8.1. Нунтаглах болон шигшүүрийн төхөөрөмжийн шийдлүүд: Хүргэлтийн өдрөөс хойш арван найман (18) сар, эсвэл Ашиглалтад оруулснаас хойш арван хоёр (12) сар;

11.8.2. Машинд (LHD ачигч, ачааны машин, өрмийн машин, гэх мэт) бэлэн суурилуулсан автоматжуулалтын хувьд тухайн машины баталгаат хугацааг баримтална;

11.8.3. Бэлэн суурилуулснаас бусад автоматжуулалтын систем: арван хоёр (12) сар;

11.8.4. Төхөөрөмжүүд: арван хоёр (12) сар;

11.8.5. Гал унтраах систем: арван хоёр (12) сар.

11.9. Сэндвикийн Сэлбэг хэрэгсэл

11.9.1. Ерөнхий сэлбэг хэрэгсэл: засаж тохируулсан өдрөөс хойш гурван (3) сар эсвэл таван зуун (500) ажиллагааны цаг, хамгийн дээд тал нь Хүргэлтийн өдрөөс хойш зургаан (6) сар;

11.9.2. Гидравлик чулуун өрөм: хуучин өрмийн машинд суурилуулсан гидравлик чулуун өрөм: Хүргэлтээс хойш зургаан (6) сар эсвэл таван зуун (500) цохилтын цаг.

11.10. Сэндвикийн Чулуулгийн багаж хэрэгсэл

11.10.1. Өрөмдлөгийн богино хугацаанд элэгдэх эд анги: Хүргэлтийн өдрөөс хойш гурван (3) сар;

11.10.2. Зүсэлтийн багаж хэрэгсэл болон боолт: Хүргэлтийн өдрөөс хойш гурван (3) сар;

11.10.3. Нунтаглах машин болон сэлбэг хэрэгслүүд: Хүргэлтээс хойш (6) сар эсхүл (зөвхөн сэлбэг хэрэгсэл) засаж тохируулсан өдрөөс хойш гурван (3) сар.

11.10.4. Сэндвик нь бусад аливаа чулуулгийн багаж хэрэгсэлд баталгаа гаргахгүй, хариуцлага хүлээхгүй болно.

11.11. Сэндвикийн Богино хугацаанд элэгдэх бараа

11.11.1. Газартай харьцах эд анги (Шаркын бүтээгдэхүүнийг оролцуулаад): Хүргэлтийн өдрөөс хойш гурван (3) сар;

- 11.11.2. Манган элэгдэх эд анги (мантле халаагуур, хүнхэр холхивч болон хацарт бутлагчийн хавтанг багтаана): Хүргэлтийн өдрөөс хойш гурван (3) сар;
- 11.11.3. Цохилтот бутлуурын элэгдэх эд анги: Хүргэлтээс хойш гурван (3) сар;
- 11.11.4. Шигшүүрийн төхөөрөмж ба элэгдлээс хамгаалах бүтээгдэхүүн: Хүргэлтийн өдрөөс хойш гурван (3) сар;
- 11.11.5. Бутлуурын эд анги: Хүргэлтээс хойш гурван (3) сар;
- 11.11.6. Нунтаглах аяга болон нунтаглах дугуй: Хүргэлтээс хойш гурван (3) сар;

11.12. Сонголтоор авах уртасгасан баталгаа. Сэндвик тусдаа бие даасан баримт бичиг/гэрээ байгуулах замаар Худалдан авагчид уртасгасан баталгаа худалдан авах боломж олгож болно. Аливаа уртасгасан баталгааг тухайн уртасгасан баталгааны баримт бичигт заасан нөхцөл, бозлын дагуу хэрэгжүүлнэ.

12. Үл хамаарах тохиолдлууд

12.1. Хуулиар зөвшөөрөгдсөн боломжит хэмжээнд:

- 12.1.1. холбогдох хууль тогтоомжид шууд бусаар тусгасан бүх нөхцөл, болзол, баталгаа, үүрэг, амлалт эсвэл эрх сэргээх арга хэмжээ авах эрх нь Сэндвикийн Бараанд хамаарахгүй;
- 12.1.2. Сэндвик анхдагч эцсийн хэрэглэгч Худалдан авагчаас бусад аливаа талын өмнө аливаа хариуцлага хүлээхээс шууд татгалзаж байна.

12.2. Сэндвик дараахад аливаа баталгаа гаргахгүй бөгөөд дараах тохиолдлуудад хариуцлага хүлээхгүй болно. Үүнд:

- 12.2.1. Сэндвикийн Тоног төхөөрөмжийн хэвийн элэгдэл, хорогдол, хөдөлгүүрийн тохируулга, засвар, үзлэг гэх зэргийг багтаах боловч үүгээр хязгаарлагдахгүй ердийн засвар үйлчилгээ, мөн үүнтэй холбоотой аливаа эвдрэл гэмтэл;
- 12.2.2. Сэндвикийн Сэлбэг хэрэгслийн хэвийн элэгдэл, хорогдол болон үүнээс үүдсэн эвдрэл;
- 12.2.3. Жийргэвч, шүүлтүүр, хоолой, сэнсний ремень, дугуй, нэмэлт хэрэгсэл, эрэг, шураг, шайп, чулуулгийн өрмийн холбогч хэсгүүд, хавчуур, өрц, өрмийн хошууны тогтоох хэсгийн эд ангиуд, туузан дамжуургын гинж болон дугуй, гал хамгаалагч, шүрших хошуу, завсрын дугуй, чиргүүлийн кабель, резинэн эмжээр, өрмийн хошууны хонгио, шүд, хутга, шатахуун, хөргөгч шингэн, тос, тосолгоо, хэрэгсэл (доргилт хамгаалагч хэрэгсэл, зөөллөгч хэрэгсэл), тавцангийн хонгио, нунтаглах аягатай харьцах эд ангийг хамруулах боловч үүгээр хязгаарлагдаагүй бүхий л элэгдэх эд анги болон богино хугацаанд элэгдэх бараа (Сэндвикийн Богино хугацаанд элэгдэх бараа);
- 12.2.4. Худалдан авагч Сэндвикийн Тоног төхөөрөмжийг зөв зохистой ажиллуулаагүй буюу ашиглаагүйгээс, даац хэтрүүлсэн, үйлчилгээний болон ажиллуулах зааврыг анхаарч мөрдөөгүйгээс үүдсэн эсвэл осол гэмтэл, тогтоосон хүчин чадлыг хэтрүүлж ажиллуулсан эсвэл цахилгааны оролтыг хэтрүүлсэн буюу дагаж мөрдөөгүйн улмаас учирсан эвдрэл гэмтэл;

- 12.2.5. Худалдан авагч Сэндвикийн Барааг холбогдох Сэндвикийн хадгалалт, ашиглалтын заавар горимын дагуу зүй зохистой хадгалаагүй, ашиглаагүй эсвэл суурилуулаагүйн улмаас учирсан эвдрэл гэмтэл, хохирол;
- 12.2.6. Үйлдвэрлэлийн стандартын дагуу зохион бүтээж, үйлдвэрлэсэн эд ангиудыг гүнзгий болон/эсвэл ширүүн урсгалтай усанд, чанарын шаардлага хангахгүй зам, шороо, тоостой, агааржуулалт муутай нөхцөлд ажиллуулж ашиглалтын хугацаа дуусахаас өмнө эвдэрсний улмаас учирсан хохирол;
- 12.2.7. Худалдан авагчийн (i) өгсөн материал эсвэл (ii) өгсөн, заасан эсвэл тодорхойлсон загвараас үүдсэн доголдол гэмтэл эсвэл (iii) Худалдан авагчийн үйлдэл, шаардлагын улмаас учирсан аливаа доголдол, гэмтэл;
- 12.2.8. Сэндвик эсвэл Сэндвикийн томилсон төлөөлөгчид Худалдан авагчийн өгсөн, хүргүүлсэн дутуу, буруу, зөрүүтэй шаардлага, ашиглалтын өгөгдөл, бусад мэдээллээс үүдсэн аливаа доголдол, эвдрэл гэмтэл;
- 12.2.9. Сэндвикийн Сэлбэг хэрэгсэл биш аливаа сэлбэг, эд ангиас үүдсэн аливаа эвдрэл гэмтэл;
- 12.2.10. 8.3-р хэсгийн дагуу Сэндвикийн Сэлбэг, Богино хугацаанд элэгдэх барааны оронд өөр сэлбэг суурилуулсан, угсарсан, нийлүүлсний улмаас Сэндвикийн Бараанд гарсан доголдол;
- 12.2.11. Гуравдагч этгээдийн нийлүүлсэн сэлбэг, эд ангиас үүдэж Сэндвикийн Бараанд гарсан эвдрэл гэмтэл;
- 12.2.12. OEM буюу анхны тоног төхөөрөмж үйлдвэрлэгчийн заасан программтай хамт ашиглаагүй эсвэл суурилуулаагүй Сэндвикийн Сэлбэг хэрэгсэл;
- 12.2.13. Хөдөлмөрийн зардал, байр, хоол, зам, тээврийн зардал гэх мэт аливаа зардал;
- 12.2.14. Сэндвикээс бичгээр өөрөөр мэдэгдээгүй тохиолдолд Сэндвикийг зүгээс хийсэн буюу боломжтой болгосон бүтээгдэхүүн сайжруулалт эсвэл шинэчлэл;
- 12.2.15. Жийргэвчийг солих, чангалах эсвэл тохируулга хийх гэх мэтээр анхан шатны засвар үйлчилгээ хийх замаар засаж, сэлбэх боломжтой Сэндвикийн Сэлбэг хэрэгсэл эсвэл Сэндвик Тоног төхөөрөмж.

13. Баталгааны бүртгэл

- 13.1.** Сэндвик Тоног төхөөрөмжийг Ашиглалтад оруулах үед эхлүүлэх баримт бичиг болон Баталгааны Бүртгэлийн маягыг бөглөж, Худалдан авагч гарын үсэг зурж, Ашиглалтад оруулснаас хойш арван дөрвөн (14) өдрийн дотор Сэндвикийн төлөөлөгчид хүргүүлнэ. Холбогдох Сэндвикийн Барааны хувьд Баталгааны бүртгэлийг цахимаар Баталгааны бүртгэлд зориулсан дижитал платформ ашиглан гүйцэтгэж болно.
- 13.2.** Аливаа баталгааны нэхэмжлэлийг авч үзэж, шийдвэрлэхээс өмнө бүрэн бөглөж, гарын үсэг зурсан Баталгааны Бүртгэлийн маягыг Сэндвикт хүргүүлсэн эсвэл дижитал платформуор бүртгэл хийлгэн хүргүүлсэн байх шаардлагатай.
- 13.3.** Хөдөлгүүрийн баталгааны бүртгэлийг Ашиглалтад оруулах үед тухайн орон нутгийн OEM-ийн төлөөлөгчөөр тусад нь гүйцэтгүүлнэ.

14. Баталгааны нэхэмжлэлийг боловсруулах

14.1. Худалдан авагчийн нэхэмжлэл. Худалдан авагч энэхүү Баталгаанд заасан эрхээ хэрэгжүүлэхийн тулд Сэндвик эсвэл Сэндвикийн Дистрибютрт аливаа гарсан доголдлын тухай цаг адалгүй бичгээр мэдэгдэж, Сэндвикт тухайн доголдлыг шалгаж нягтлан, засаж арилгахад шаардагдах боломж олгох үүрэгтэй.

Доголдол нь эвдрэл учруулж болзошгүй тохиолдолд Худалдан авагч нэн даруй Сэндвик эсвэл Сэндюикийн дистрибютрт бичгээр мэдэгдэнэ. Худалдан авагч ийнхүү мэдэгдээгүйн улмаас Сэндвикийн Бараанд гарч болзошгүй эвдрэх аливаа эрсдэлийг хариуцна. Худалдан авагч тухайн эвдрэл хохирлыг бууруулах талаар зохих арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд Сэндвикийн зүгээс үүнтэй холбогдуулж өгсөн аливаа зааврыг дагаж мөрдөнө.

14.2. Баталгааны өргөдлийн маягт. Баталгааны нэхэмжлэлийг “Баталгааны өргөдлийн” маягтыг ашиглаж бичгээр хүргүүлнэ. Худалдан авагч нь тухайн маягтыг бүрэн гүйцэд бөглөж, холбогдох доголдлыг илрүүлснээс хойш хуанлийн арван дөрвөн (14) өдрийн дотор Сэндвикийн төлөөлөгчид хүргүүлнэ. Энэхүү хугацаанд ирүүлээгүй нэхэмжлэлийг хүлээн авахгүй бөгөөд Худалдан авагч энэхүү Баталгааны дагуу доголдлыг арилгуулах эрхээ эдлэх боломжгүй болно. Доголдол бүрийг тус тусад нь Баталгааны өргөдлийн маягтад тусгаж өгнө.

14.3. Нотолгоо. Сэндвикийн Баталгааны өргөдлийн маягтад доголдол, эвдрэлийг харуулсан тод гарсан гэрэл зураг болон засвар үйлчилгээ хийгдсэн тухай мэдээллийг (цуглуулсан мэдээлэл болон/эсвэл тосны дээжийн тест болон/эсвэл хамааралтай бол тосны даралтын тохируулгыг багтаасан) хавсаргасан байна. Шаардлагатай тохиолдолд Сэндвик нэмэлт мэдээлэл буюу ашиглалтын мэдээллийг шаардаж болно. Энэ тохиолдолд Худалдан авагч тухайн шаардсан мэдээллийг Сэндвикийн шаардлагыг хүлээн авснаас хойш таван (5) өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй. Чулуулгийн өрөмтэй холбоотой Сэндвикийн Баталгааны өргөдлийн маягтад “Өрмийн эвдрэлийн мэдээлэл”-ийг оруулсан байна. Нэхэмжлэл компрессорын эвдрэлтэй холбоотой тохиолдолд, босоо өрмийн эвдрэлийн тухай Сэндвикийн Баталгааны өргөдлийн маягтад “Компрессорын эвдрэлийн мэдээлэл”-ийг багтаасан байна.

14.4. Хөдөлгүүр. Хөдөлгүүртэй холбоотой нэхэмжлэлийг орон нутгийн OEM-ийн хөдөлгүүр хариуцсан төлөөлөгч хүлээн авч боловсруулна. Худалдан авагч нь тухайн нэхэмжлэлийн мэдэгдлийн хувийг Сэндвикт илгээнэ.

14.5. Худалдан авсан тухай нотолгоо. Бүхий л Баталгааны нэхэмжлэлд худалдан авсан нотолгоог хавсаргасан байх бөгөөд үүний жишээ нь:

14.5.1. Худалдан авалтын захиалгын хуулбар эсвэл худалдан авалтын захиалгын дугаар;

14.5.2. Төлбөрийн нэхэмжлэлийн хуулбар эсвэл төлбөрийн нэхэмжлэлийн дугаар; эсвэл

14.5.3. Ажлын зардал хуваарилалтын тайлан.

14.6. Буцаалтын журам. Худалдан авагч нь Сэндвикийн зүгээс шалгах боломжийг олгох зорилгоор нэхэмжлэл гаргасан доголдолтой Сэндвикийн Бараа, эсвэл Сэндвикийн Барааны эд анги, хэсгийг холбогдох нэхэмжлэлийг шийдвэрлэснээс хойш 90 өдөр хадгалах үүрэгтэй бөгөөд Сэндвикийн хүсэлтээр тухайн доголтой эд анги, хэсгийг Сэндвикийн зааврын дагуу түүний зардлаар заасан газарт хүргүүлнэ. Сэндвикээс бичгээр урьдчилан мэдэгдээгүй тохиолдолд аливаа эд ангийг

Сэндвикт буцааж хүргүүлэхгүй. Нэхэмжлэлийг хүлээн авсан тохиолдолд баталгааны асуудлыг шийдвэрлэсний дараа буцаалт хийсэн доголдолтой эд анги, хэсгийн эзэмших эрхийг Сэндвикт шилжүүлнэ.

14.7. Буцаалт хийх хаяг. Эд ангийг өөрийн улс дах Сэндвикийн төлөөлөгчийн газарт буцаана.

14.8. Давж заалдах. Баталгааны нэхэмжлэлийн шийдвэрийг Сэндвикийн төлөөлөгчид тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш хуанлийн (14) өдрийн дотор бичгээр давж заалдах бөгөөд хэрэв тухайн хугацаа өнгөрсөн бол уг шийдвэр эцсийн шийдвэр болно.

15. Баталгааны дагуу Сэндвикийн хүлээх үүрэг

15.1. Сэндвикийн Баталгааны Өргөдлийн маягтыг хүлээн авч, нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд энэхүү Баталгааны дагуу Сэндвикийн хүлээх үүрэг дараахаар хязгаарлагдах бөгөөд Сэндвик өөрөө сонгох эрхтэй болно:

15.1.1. Сэндвикийн Барааны үнийг өөрийн нөөц нэмэгдүүлэх захиалгын үнээр тооцож буцаан олгох;

15.1.2. Сэндвикийн Барааг засах;

15.1.3. Сэндвикийн Барааг үнэ төлбөргүйгээр DDP (Инкотермс 2010, худалдан авагч талд хүлээлгэн өгөх хүртэл бүх зардлыг хариуцна) нөхцөлөөр Сэндвикийн төлөөлөгчийн албан байранд сольж өгнө; эсвэл

15.1.4. Бутлуурын доголдолтой эд анги, хэсгийг үнэ төлбөргүйгээр FCA (Инкотермс 2010, Худалдагч тал барааг худалдан авагч талд хүлээлгэн өгөх хүртэл хариуцна) нөхцөлөөр Сэндвикийн төлөөлөгчийн албан байранд сольж өгнө.

15.2. Сольж өгсөн эд ангийн баталгаа. Сэндвикийн Тоног төхөөрөмж эсвэл Сэндвикийн Сэлбэг хэрэгслийн доголдлыг засаж арилгасан тохиолдолд Сэндвикийн Тоног төхөөрөмж эсвэл Сэндвикийн Сэлбэг хэрэгслийн сольсон эсвэл зассан эд ангийн баталгаа оригинал буюу анхны Сэндвикийн Тоног төхөөрөмж, Сэндвикийн Сэлбэг хэрэгслийн баталгаатай нэгэн зэрэг дуусна.

15.3. Сэндвикийн Чулуулгийн Эд анги болон Сэндвикийн Богино хугацаанд элэгдэх барааны баталгаа. Сэндвикээс Сольж өгсөн Сэндвикийн Чулуулгийн Эд анги болон Сэндвикийн Богино хугацаанд элэгдэх бараа нь шинэ Сэндвикийн Чулуулгийн Эд анги болон Сэндвикийн Богино хугацаанд элэгдэх барааны баталгаатай адил баталгаатай байна.

16. Хязгаарлалт

16.1. Хариуцлагын ерөнхий хязгаарлалт Хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд аливаа Гэрээ буюу бусад зүйлтэй холбоотой нэг удаагийн эсвэл хэд хэдэн нэхэмжлэлийн хувьд нийтэд нь Сэндвикийн хүлээх хариуцлагын хэмжээ тухайн хариуцлага үүссэн Сэндвикийн Барааны Гэрээний дагуу төлөх худалдан авах үнийн дүнгээс хэтрэхгүй байна.

16.2. Босго үнийн дүн Баталгааны нэхэмжлэл нь тавин евро (50 евро) эсвэл үүнтэй дүйцэх хэмжээний бусад валют буюу түүнээс дээш хэмжээтэй байх шаардлагатай болно.

16.3. Зөвхөн Сэндвикийн Бараа Энэхүү Баталгаа нь гагцхүү Сэндвикийн Бараанд хамааралтай. Сэндвик Сэндвикийн бус бараатай холбоотой хариуцлага хүлээхгүй Сэндвикийн бус бараа нь

Сэндвикийн Бараанд аливаа гэмтэл учруулсан тохиолдолд Сэндвикийн бус барааг ашигласан нь энэхүү Баталгааг хүчингүй болгох буюу үүнд нөлөөлөх нөхцөл байдал болно. Үүнээс гадна энэхүү 4-р зүйлд заасан тохиолдлуудаас гадна дараах тохиолдлуудад гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахгүй. Үүнд:

16.3.1. Сэндвикийн Тоног төхөөрөмжид Сэндвикийн Сэлбэг хэрэгслээс өөр сэлбэг хэрэглэсэн; эсвэл

16.3.2. Сэндвикийн Сэлбэг хэрэгсэл, Сэндвикийн Чулуулгийн эд анги эсвэл Сэндвикийн Богино хугацаанд элэгдэх барааг салган авч Сэндвикийн Тоног төхөөрөмжөөс өөр тоног төхөөрөмжид ашигласан буюу OEM-с санал болгосон программын хамт ашиглаагүй буюу суурилуулаагүй бол.

16.4. Түдгэлзүүлэхгүй тухай Энэхүү Баталгааг огт ашиглаагүй буюу тогтмол ашиглаагүй гэх үндэслэлээр болон аливаа бусад өөр үндэслэлээр түдгэлзүүлэхгүй.

16.5. Шилжүүлэхгүй тухай Хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд, Худалдан авагч энэхүү баталгаагаар эдлэх аливаа эрхээ гуравдагч этгээдэд шууд эсвэл дам байдлаар шилжүүлэхийг оролдсон тохиолдолд бүх баталгаа нэн даруй хүчингүй болно гэдгийг Худалдан авагч хүлээн зөвшөөрч, ойлгож байна. Сэндвик Худалдан авагчид бичгээр урьдчилан зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд Сэндвикээс олгосон баталгааг аливаа гуравдагч талд шилжүүлэх гэсэн Худалдан авагчийн аливаа оролдлого хүчин төгөлдөр бус, хүчингүй байна. Тухайн зөвшөөрлийг олгох асуудал Сэндвикийн Тоног төхөөрөмжид хийх үзлэг шалгалт болон тусдаа бие даасан Баталгааны Бүртгэлийн маягтаас шалтгаална. Ямар ч тохиолдолд шилжүүлгийг зөвшөөрсөн гэдэг нь Сэндвикийн Тоног төхөөрөмжийн анхны баталгаат хугацааг сунгах үндэслэл болохгүй.

16.6. Бүх Баталгаа Энэхүү Баталгаа нь аливаа бусад шууд буюу шууд бус эсвэл хуульд заасан бүхий л баталгаа, нөхцөлийг орлоно. Сэндвик нь Сэндвикийн аливаа Барааны чанар, гүйцэтгэл, доголдолгүй ажиллагаатай холбогдуулж шууд буюу таамагласан аливаа мэдэгдэл, амлалт, баталгаа (нэмэлт, урьдчилсан эсвэл бусад байдлаар) өгөхгүй. Ялангуяа, энгийн хэрэгцээнд нийцэх байдал, ажлын шаардлага хангах байдал, тодорхой чанар, үр дүнд хүргэх чадварын талаар бодит эсвэл таамагласан баталгаа өгөхгүй. Сэндвикээс бичгээр өгснөөс бусад тохиолдолд шууд эсвэл таамагласан аливаа бусад баталгаа өгөхгүй. Сэндвик болон Худалдан авагчийн хооронд харилцан тохиролцсон баталгааны бүх нөхцөл, бозлыг энэхүү Баталгаанд багтаасан болно.

16.7. Үр дагаврын хохирол хариуцахгүй тухай Алдагдал хохирол хэрхэн үүссэн эсэх болон нэхэмжлэлийн үндэслэлээс (үүнд гэрээ эсвэл баталгааг зөрчсөнтэй холбоотой нэхэмжлэл, гэм хор (tort) (хайхрамжгүй байдлыг оролцуулаад), бүтээгдэхүүний хариуцлага (product liability), нөхөн төлбөр (indemnity), нэхэмжлэлээс тодорхой хувь хүртэх нөхцөлтэй нэхэмжлэл (contribution claim), шууд хариуцлагатай холбоотой (strict liability), мөн бусад хууль, эрх зүйн ойлголтын хүрээнд гарч болох нэхэмжлэлийг оролцуулна) үл хамаарч, мөн хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд Сэндвик нь аливаа үр дагаврын, гэнэтийн, шууд бус, онцгой, шийтгэлийн шинжтэй хохирлын нөхөн төлбөр болон аливаа бодит эсвэл хүлээгдэж байсан орлого, ашгийн алдагдал; бизнес эсвэл үйлчлүүлэгчээ алдах; хуримтлал эсвэл хүлээгдэж байсан хуримтлалын алдагдал; гэрээ байгуулах боломж эсвэл гэрээгээр, аливаа бусад гэрээ, тухайлбал Гэрээтэй холбоотойгоор олж авах байсан боломжийн алдагдал; аливаа бусад боломжоо алдсан; зах зээлд нэвтрэх эрхээ алдах; хангамжийн өөр хувилбар эсвэл Сэндвикийн Барааг орлох өөр бараа олох боломжоо алдах; үйлдвэрлэлийн алдагдал эсвэл аливаа саатлын (үүнд дуусгаагүй ажлыг дуусгахад зарцуулсан зардлыг багтаана) улмаас үүдсэн алдагдал; Гэрээ эсвэл Сэндвикийн Бараатай холбогдуулж Худалдан авагчийн

гуравдагч талтай байгуулсан гэрээ, тухайлбал худалдах, худалдан авах гэрээ эсвэл ирээдүйд худалдан авах гэрээгээр хүлээсэн алдагдал; ашиглалтын алдагдал, эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн алдагдал; зогсолт, үйл ажиллагааны явуулаагүйн улмаас үүссэн алдагдал; үндсэн хөрөнгө эсвэл үйл ажиллагааны зардлын нэмэгдэл; нэр хүндээ алдсанаас үүссэн алдагдал; мэдээлэл, өгөгдлийн алдагдал; нэмэгдсэн санхүүжилтийн зардал эсвэл шинэ санхүүжилт авахад гаргасан зардал; ба менежер, ажилтнуудын зарцуулсан цагийн төлөө шууд хариуцлага хүлээхгүй болно. Худалдан авагч нь Сэндвик, Сэндвик Группийн гишүүд, эсвэл түүний аливаа хамаарал бүхий этгээд, гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч, зөвлөх, ажилтан, төлөөлөгч, Сэндвикийн Дистрибютрын эсрэг аливаа үр дагаврын хохирол, энэхүү 8.7-р зүйлд заасан аливаа төрлийн алдагдал, хохирлыг төлүүлэх нэхэмжлэл, шаардлага гаргах эрхээс татгалзаж, эдгээр этгээдийг үүнтэй холбоотой аливаа хохирлоос ангид байлгаж, хохиролгүй болгоно.

- 16.8.** Сэндвикийн баталгаанууд үндсэн зорилгоо биелүүлээгүй эсвэл хүчингүй буюу хэрэгжих боломжгүй гэж тооцогдсон эсэхээс үл хамааран энэхүү Баталгаанд заасан Сэндвикийн хүлээх хариуцлагын хязгаарлалт хүчинтэй үйлчилнэ.

Чухал санамж: Сэндвикийн Дистрибютр Баталгаатай холбогдуулж аливаа мэдэгдэл, амлалт, зөвшөөрөл өгөх эсвэл энэхүү Баталгааны нөхцөл, хязгаарлалтыг аливаа байдлаар өөрчлөх эрхгүй байна. Сэндвик гагцхүү энэхүү баримт бичигт заасан баталгаануудыг өгсөн болно.

СЭНДВИКИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	
Бүтээгдэхүүн	Баталгаат хугацаа
Бутлуур, Нунтаглагч болон Шигшүүр	
Бутлуур	Арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) тээвэрлэлтийн цаг
Нунтаглагч (Зөөврийн)	Арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) үйл ажиллагааны цаг
Шигшүүр ба шигшүүр рүү шахагч зам (Зөөврийн)	Арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) үйл ажиллагааны цаг
Нунтаглагч (Суурин)	Арван хоёр (12) сар
Шигшүүр ба шигшүүр рүү шахагч зам (Суурин)	Арван хоёр (12) сар
Өрмийн машин	
Эргэлдэгч, өндөр даралтын өрмийн машин (компрессорын моторын гол (air ends), өрмийн толгой, Бүлүүрт шахуурга, Мотор, Шахагч болон Хөшүүргийн цилиндрээс бусад)	Арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) хөдөлгүүрийн цаг
Air Ends (компрессорын моторын гол)	хорин дөрвөн (24) сар болон эргэлтэт өрмийн хувьд цагийн хязгааргүй
Өрмийн толгой	арван хоёр (12) сар болон эргэлтэт өрмийн хувьд цагийн хязгааргүй
Бүлүүрт шахуурга ба Мотор	арван хоёр (12) сар болон эргэлтэт өрмийн хувьд цагийн хязгааргүй
Шахагч ба Хөшүүргийн цилиндр	арван хоёр (12) сар болон эргэлтэт өрмийн хувьд цагийн хязгааргүй
Гадаргуугийн өрмийн машин	Арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) хөдөлгүүрийн

СЭНДВИКИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	
Бүтээгдэхүүн	Баталгаат хугацаа
(компрессорын моторын гол, Бүлүүрт шахуурга ба Мотор, Гидравлик чулуун өрмөөс бусад)	цаг
Air Ends (компрессорын моторын гол)	арван хоёр (12) сар бөгөөд гадаргуугийн өрмийн хувьд цагийн хязгааргүй
Бүлүүрт шахуурга ба Мотор	арван хоёр (12) сар бөгөөд гадаргуугийн өрмийн хувьд цагийн хязгааргүй
Гидравлик чулуун өрөм	арван хоёр (12) сар эсвэл гадаргуугийн өрмийн хувьд нэг мянган (1000) цохилтын цаг
Газрын гүний өрмийн машин	арван хоёр (12) сар
Гидравлик чулуун өрөм	арван хоёр (12) сар эсвэл нэг мянган (1000) цохилтын цаг
Хайгуулын өрмийн машин	арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) цохилтын цаг
Газрын гүний өрмийн машин (бэлэн суурилуулсан холхих хурдасгагчаас бусад)	арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) гидравлик хүчний блок цаг
Бэлэн суурилуулсан холхих хурдасгагч	нэг мянган (1000) ажиллагааны цаг
Өрөмдлөгийн алх (DTH) (шинэ өрмийн машинтай хамт худалдаж авсан тохиолдолд)	гурван (3) сар
Гадаргуугийн өрмийн машин (Air Ends, Өрмийн толгой, Бүлүүрт шахуурга ба Мотороос бусад)	арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) хөдөлгүүрийн цаг
Air Ends (компрессорын моторын гол)	арван хоёр (12) сар бөгөөд гадаргуугийн өрмийн машины хувьд цагийн хязгааргүй
Өрмийн толгой	арван хоёр (12) сар эсвэл гадаргуугийн өрмийн машины хувьд хоёр мянган (2000) хөдөлгүүрийн цаг
Бүлүүрт шахуурга ба Мотор	арван хоёр (12) сар бөгөөд гадаргуугийн өрмийн машины хувьд цагийн хязгааргүй
Ачилт, Тээвэрлэлт	
LHD буюу ачих, тээвэрлэх, буулгах ачигч машин болон ачааны машин	арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) хөдөлгүүрийн цаг эсвэл цахилгаан хэрэгслийн хувьд ажиллагааны цаг;
Түргэн салгах системийн төхөөрөмжүүд	зургаан (6) сар.
Механик зүсэлтийн машин	
Механик зүсэлтийн машин	Арван хоёр (12) сар
Газрын гүнд тээвэрлэлт хийх машин болон тусгай зориулалтын бага оврын ачааны машин	арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) зөөвөрлөлтийн цаг;
Зүсэлтийн машины дагалдах хэрэгсэл	Хүргэлтээс хойш зургаан (6) сар
Хурдасгагч болон Компрессор	
Холхих хурдасгагч	арван хоёр (12) сар эсвэл нэг мянган (1000) үйл ажиллагааны цаг
Шурагт хурдасгагч болон компрессор	арван хоёр (12) сар эсвэл хоёр мянган (2000) үйл ажиллагааны цаг
Систем	
Машинд (LHD, ачааны машин, өрмийн машин гэх мэт) бэлэн суурилуулсан автоматжуулалт	суурилуулсан машины баталгаат хугацааны нэг хэсэг болгон багтаасан

СЭНДВИКИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	
Бүтээгдэхүүн	Баталгаат хугацаа
Дамжуулан тээвэрлэх болон шигшүүрийн төхөөрөмжийн шийдлүүд	Хүргэлтээс хойш арван найман (18) сар, эсвэл Ашиглалтад оруулснаас хойш арван хоёр (12) сар
Бэлэн суурилуулснаас бусад автоматжуулалтын систем	арван хоёр (12) сар
Төхөөрөмжүүдийн систем	арван хоёр (12) сар
Гал унтраах систем	арван хоёр (12) сар

СЭНДВИКИЙН СЭЛБЭГ ХЭРЭГСЭЛ	
Бүтээгдэхүүн	Баталгаат хугацаа
Ерөнхий Сэлбэг хэрэгсэл	засаж тохируулсан өдрөөс хойш гурван (3) сар эсвэл таван зуун (500) ажиллагааны цаг, хамгийн дээд тал нь Хүргэлтийн өдрөөс хойш зургаан (6) сар
Хуучин өрмийн машинд суурилуулсан Гидравлик чулуун өрөм	Хүргэлтээс хойш зургаан (6) сар эсвэл хуучин өрөмд суурилуулснаас хойш таван зуун (500) цохилтын цаг
Нунтаглах машины сэлбэг хэрэгсэлүүд	Хүргэлтээс хойш зургаан (6) сар эсхүл засаж тохируулсан өдрөөс хойш гурван (3) сар

СЭНДВИКИЙН ЧУЛУУЛГИЙН БАГАЖ	
Бүтээгдэхүүн	Баталгаат хугацаа
Өрөмдлөгийн богино хугацаанд элэгдэх эд анги	Хүргэлтээс хойш гурван (3) сар
Зүсэлтийн багаж хэрэгсэл болон бэхэлгээ	Хүргэлтээс хойш гурван (3) сар
Нунтаглах машин	Хүргэлтээс хойш зургаан (6) сар

СЭНДВИКИЙН БОГИНО ХУГАЦААНД ЭЛЭГДЭХ БАРАА	
Бүтээгдэхүүн	Баталгаат хугацаа
Манган элэгдэх эд анги	Хүргэлтээс хойш гурван (3) сар
Газартай харьцах эд анги	Хүргэлтээс хойш гурван (3) сар
Цохилтот бутлуурын элэгдэх эд анги	Хүргэлтээс хойш гурван (3) сар
Шигшүүрийн төхөөрөмж ба элэгдлээс хамгаалах бүтээгдэхүүн	Хүргэлтээс хойш гурван (3) сар
Бутлуурын эд анги	Хүргэлтээс хойш гурван (3) сар
Нунтаглах аяга болон Нунтаглах дугуй	Хүргэлтээс хойш гурван (3) сар